



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ  
(цөмийн энерги)**

2009 оны 7 дугаар сарын 22-ны  
өдөр

Улаанбаатар хот

**Дугаар 222**

**“Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2009 оны 45 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:**

1. “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийг 1 дүгээр хавсралт, “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн төлөвлөгөө”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор, Цөмийн энергийн газрын дарга С.Энхбат нарт үүрэг болгосугай.

3. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Цөмийн энергийн газрын дарга С.Энхбатад даалгасугай.

4. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд**

**С.БАЯР**

Монгол Улсын сайд,

Засгийн газрын Хэрэг

Эрхлэх газрын дарга

**Б.ДОЛГОР**